



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 5/689

Улаанбаатар хот

Б.Сарнайд буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.7 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Гаалийн ерөнхий газрын харьяа "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Баасангийн Сарнайд төрсөн ах нь нас барсан тул нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид зарцуулах 420000 /дөрвөн зуун хорин мянга/ төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ